



**“ШИВЭЭ-ОВОО”  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны үйл ажиллагааны  
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс  
гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн ТОГТООХ нь:

1. “Шивээ-Овоо” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, “сайжруулах шаардлагатай” гэж баталсугай.

2. “Шивээ-Овоо” ХК 2025 онд компанийн үйлдвэрлэлийн зорилтот түвшний биелэлтийг хангах, санхүү эдийн засгийн хувьд ашигтай ажиллах, өр авлагыг багасгах, өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний эрэлттэй уялдуулан үйлдвэрлэлийн найдвартай хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЖАВЗАНПАГМА



**“ШИВЭЭ-ОВОО”**  
**ХУВЬЦААТ КОМПАНИЙН**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны санхүүгийн  
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс  
гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн ТОГТООХ нь:

1. “Шивээ-Овоо” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, “хангалттай” гэж баталсугай.

2. “Шивээ-Овоо” ХК-ийн 2025 оны батлагдсан бизнес төлөвлөгөөний хүрээнд үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, компанийн үр ашгийг нэмэгдүүлэн, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

3. Үндэсний Аудитын газрын 2024 оны санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЖАВЗАНПАГМА



**“ШИВЭЭ-ОВОО”  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

**Компанийн дүрэмд өөрчлөлт  
оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 17.9, 62 дугаар зүйлийн 62.1.1, “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн ТОГТООХ нь:

1. “Шивээ-Овоо” ХК-ийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулж баталсугай:

1.1. дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтад “гишүүд” гэснийг “дарга” гэж өөрчлөх;

1.2. дүрмийн 3 дугаар зүйлийн 3.5.1 дэх заалтад “компанийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн” гэснийг “газар, хэлтсийн” гэж өөрчлөх.

2. “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлийн байгууллагад хуулийн хугацаанд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ц.Энхтүвшин)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЖАВЗАНПАГМА



**“ШИВЭЭ-ОВОО”  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг  
томилох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 8 дугаар тогтоолыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн **ТОГТООХ нь:**

1. “Шивээ-Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон, хараат бус гишүүдээр дараах нэр дэвшигчдийг томилсугай.

1.1. Төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийг төлөөлж:

- 1.1.1. Д.Нямдэлгэр
- 1.1.2. Л.Наранчимэг
- 1.1.3. Ц.Төгсбуян
- 1.1.4. П.Билгүүн
- 1.1.5. А.Бүдээ
- 1.1.6. И.Батхүү

1.2. Хараат бус гишүүнээр:

- 1.2.1. С.Цолмон
- 1.2.2. П.Баянсан
- 1.2.3. Ц.Лхамсүрэн

2. “Шивээ-Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг эрх бүхий байгууллагаас нэр дэвшигчдийг хувийн ашиг сонирхлын зөрчилгүй болохыг тогтоосон өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЖАВЗАНПАГМА



ЭРДЭНЭС МОНГОЛ  
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ  
КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 195

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хуралд  
оролцуулах тухай

Компанийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 3.3.6, 3.5.4, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөлөл хэрэгжүүлэх журмын 2.1.1-д заасныг тус тус үндэслэн Тушаах нь:

1. “Шивээ-Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хуралд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Нэгдлийн хяналтын асуудал хариуцсан менежер Н.Жавзанпагма, Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Ц.Төгсбуян /саналын эрхтэй/, Түлш, эрчим хүчний группийн менежер Н.Пүрэвдорж, Гэрээ, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн О.Тэлмүүн нарыг томилон оролцуулсугай.

2. “Шивээ-Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлыг зохих журмын дагуу даргалахыг Н.Жавзанпагмад даалгасугай.

3. “Шивээ-Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хуралд баримтлах удирдамжийг хавсралтаар баталсугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон талаарх тайланг 2025 оны 5 дугаар сард багтаан тайлагнахыг Н.Жавзанпагмад үүрэг болгосугай.


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.НАРАНЦОГТ

1425010421

“Эрдэнэс Монгол” ХХК Гүйцэтгэх захирлын  
2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн  
1/15 дугаар тушаалын хавсралт



**“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРАЛД “ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭГЧИД ӨГӨХ УДИРДАМЖ**

“Шивээ Овоо” ХК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд “Эрдэнэс Монгол” ХХК-ийг төлөөлөн оролцож дор дурдсан асуудлаар шийдвэр гаргахдаа Компанийн тухай хууль, Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэр, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрэм, “Шивээ Овоо” ХК-ийн дүрэм, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү удирдамжийг баримтална.

Нэг. “Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр хуралдах ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

- 1.1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
- 1.2. Компанийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
- 1.3. Ногдол ашгийн талаар гаргасан шийдвэрийн танилцуулга;
- 1.4. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай ;
- 1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлантай танилцах;
- 1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай.

Хоёр. Хувьцаа эзэмшигч бөгөөд хувьцаа эзэмшигчийн төлөөлөл хэрэгжүүлэгч нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар шийдвэр гаргахдаа дараах удирдамжийг удирдлага болгоно:

2.1. Хэлэлцэх асуудлын 1.1-д заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхдээ “Шивээ Овоо” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах санал өгөх;

2.2. Хэлэлцэх асуудлын 1.2-т заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхдээ “Шивээ Овоо” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж санал, дүгнэлт өгөх;

2.3. Хэлэлцэх асуудлын 1.3-т заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхдээ “Шивээ Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ногдол ашгийн талаар гаргасан шийдвэртэй танилцах;

2.4. Хэлэлцэх асуудлын 1.4-т заасан асуудлын шийдвэрлэхдээ “Шивээ-Овоо” ХК-ийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулах. Үүнд:

2.4.1. дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтад “гишүүд” гэснийг “дарга” гэж өөрчлөх;

2.4.2. дүрмийн 3 дугаар зүйлийн 3.5.1 дэх заалтад “компанийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн” гэснийг “газар, хэлтсийн” гэж өөрчлөх.

2.5. Хэлэлцэх асуудлын 1.5-д заасан асуудлын шийдвэрлэхдээ “Шивээ-Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлантай танилцах.

2.6. Хэлэлцэх асуудлын 1.6-д заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхдээ Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр дараах нэр дэвшигчдийг сонгож, бүрэн эрхийг эрх бүхий байгууллагаас нэр

дэвшигчдийг хувийн ашиг сонирхлын зөрчилгүй болохыг тогтоосон өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэх. Үүнд:

1.Төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийг төлөөлж:

- 1.7. Д.Нямдэлгэр
- 1.8. Л.Наранчимэг
- 1.9. Ц.Төгсбуян
- 1.10. П.Билгүүн
- 1.11. А.Бүдээ
- 1.12. И.Батхүү

2.Хараат бус гишүүнээр:

- 2.1. С.Цолмон
- 2.2. П.Баянсан
- 2.3. Ц.Лхамсүрэн

“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК

--oOo--

**“ШИВЭЭ-ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН  
КОМИССЫН ТОГТООЛ**

2025.04.24

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9, 63 дугаар зүйлийн 63.4, 67 дугаар зүйлийн 67.3.1, 69 дүгээр зүйлийн 69.1, Шивээ Овоо хувьцаат компанийн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 3.2.4, 3.2.5 дэх заалт, Шивээ Овоо хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 25/06 дугаар тогтоол, хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. “Шивээ-Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 13.419.101 ширхэг хувьцаа эзэмшдэг 1.561 хувьцаа эзэмшигчдээс брокерын пүүсүүдээр дамжуулан хуралд оролцох санал 0 ирсэн байна. Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч “Эрдэнэс Монгол” ХХК /90%/ 12.077.191 ширхэг хувьцааны эрхтэй, бусад хувьцаа эзэмшигчдийг төлөөлж 3 хүн итгэмжлэлээр, 29 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр ирж нийт 12078235 ширхэг хувьцаатай 33 хувьцаа эзэмшигчид хуралд оролцож хурлын ирц 90.0077 хувьтай байна. /Бүртгэлийг хавсаргав/

Хоёр. “Шивээ-Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц бүрдсэн тул хурлыг нээхийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд уламжилсугай.

ДАРГА:

Э.МАНДАХНАРАН

ГИШҮҮД:

Ц.МАН

Ч.ЭНХТӨР

Б.УРАНТӨГС

**“ШИВЭЭ-ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН  
КОМИССЫН ТОГТООЛ**

2025.04.24

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9, 62 дугаар зүйлийн 62.1.9, 63 дугаар зүйлийн 63.4, 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.8, 69 дүгээр зүйлийн 69.1, Шивээ овоо хувьцаат компанийн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 3.2.4, 3.2.5 дэх заалт, Шивээ-овоо хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 25/06 дугаар тогтоол, хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг үндэслэн ТОГТООХ НЬ::

Нэг. “Шивээ-Овоо” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс хийсэн дүгнэлтийг хэлэлцэж, компанийн 2024 оны үйл ажиллагааг “Сайжруулах шаардлагатай” гэж үнэлсүгэй

Хоёр: 2025 оны компанийн үйлдвэрлэлийн зорилтот түвшний биелэлтийг хангаж санхүү, эдийн засгийн хувьд ашигтай ажиллаж, өв авлагыг багасгах, өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний эрэлттэй уялдуулан үйлдвэрлэлийн найдвартай хэвийн ажиллагааг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал /Ц.Энхтүвшин/-д үүрэг болгосугай гэсэн тогтоолд хувьцаа эзэмшигчид 100 хувийн санал өгснийг тоолов.

ДАРГА:

Э.МАНДАХНАРАН

ГИШҮҮД:

Ц. Энхтөр

Ч.ЭНХТӨР

Б.УРАНТӨГС

**ШИВЭЭ-ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН  
КОМИССЫН ТОГТООЛ**

2025.04.24

Дугаар 03

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9, 63 дугаар зүйлийн 63.4, 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.8, 69 дүгээр зүйлийн 69.1, Шивээ овоо хувьцаат компанийн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 3.2.4, 3.2.5 дэх заалт, Шивээ-овоо хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 25/06 дугаар тогтоол, хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. “Шивээ-Овоо” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж “Хангалттай” гэж үнэлсүгэй.

Хоёр. Батлагдсан 2025 оны бизнес төлөвлөгөөний хүрээнд үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, компанийн үр ашгийг нэмэгдүүлж эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

Гурав. Үндэсний Аудитын газрын 2024 оны санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ц.Энхтүвшин/-д даалгасугай гэсэн тогтоолд хувьцаа эзэмшигчид 100 хувийн санал өгснийг тоолов.

ДАРГА:

Э.МАНДАХНАРАН

ГИШҮҮД:

а. ном

Ч.ЭНХТӨР

Б.УРАНТӨГС

**ШИВЭЭ-ОВОО" ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН  
КОМИССЫН ТОГТООЛ**

2025.04.24

Дугаар 04

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9, 63 дугаар зүйлийн 63.4, 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.8, 69 дүгээр зүйлийн 69.1, Шивээ овоо хувьцаат компанийн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 3.2.4, 3.2.5 дэх заалт, Шивээ-овоо хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 25/06 дугаар тогтоол, хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

**Ногдол ашиг хуваарилах эсэх тухай**

Нэг. "Шивээ Овоо" ХК нь 2024 оны санхүүгийн тайлангаар ногдол ашиг төлсний дараа төлбөрийн чадвартай байх нөхцөлийг хангахгүй байх тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй гэсэн тогтоолд хувьцаа эзэмшигчид 100 хувийн санал өгснийг тоолов.

ДАРГА:

Э.МАНДАХНАРАН

ГИШҮҮД:

А. Могой

Ч.ЭНХТӨР

Б.УРАНТӨГС

**ШИВЭЭ-ОВОО" ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН  
КОМИССЫН ТОГТООЛ**

2025.04.24

Дугаар 05

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9, 62 дугаар зүйлийн 62.1.1, 63 дугаар зүйлийн 63.4, 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.8, 69 дүгээр зүйлийн 69.1, Шивээ Овоо хувьцаат компанийн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 3.2.4, 3.2.5 дэх заалт, Шивээ-Овоо хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 25/06 дугаар тогтоол, хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. "Шивээ-Овоо" ХК-ийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулж баталсугай.

Нэгийн нэг. Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтад "гишүүн" гэснийг "дарга" гэж өөрчлөх,

Нэгийн хоёр. дүрмийн 3 дугаар зүйлийн 3.5.1 дэх заалтад "компанийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн" гэснийг "газар, хэлтсийн" гэж өөрчлөх.

Хоёр. Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Улсын бүртгэлд бүртгүүлж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ц.Энхтүвшин/-д даалгасугай.

ДАРГА:

Э.МАНДАХНАРАН

ГИШҮҮД:

Ч.ЭНХТӨР

Б.УРАНТӨГС

**“ШИВЭЭ-ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН  
КОМИССЫН ТОГТООЛ**

2025.04.24

Дугаар 06-

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9, 63 дугаар зүйлийн 63.4, 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.8, 69 дүгээр зүйлийн 69.1, Шивээ овоо хувьцаат компанийн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 3.2.4, 3.2.5 дэх заалт, Шивээ-овоо хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 25/06 дугаар тогтоол, хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны тайланг “Хангалттай” гэж үнэлсүгэй.

ДАРГА:

Э.МАНДАХНАРАН

ГИШҮҮД:

Ч.МОНГУ

Ч.ЭНХТӨР

Б.УРАНТӨГС

**“ШИВЭЭ-ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН  
КОМИССЫН ТОГТООЛ**

2025.04.24

Дугаар 07

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 67 дугаар зүйлийн 67.3.8, 71 дүгээр зүйл, 72 дугаар зүйл, 77 дугаар зүйлийн 77.2, Шивээ Овоо хувьцаат компанийн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 3.2.4, 3.2.5 дэх заалт, хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. “Шивээ Овоо” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дараах гишүүдийн бүрэн эрхийг энэхүү тогтоол гарсан өдрөөс эхлэн дуусгавар болсонд тооцсугай. Үүнд

Ердийн гишүүн

1. Д.Нямдэлгэр

2. В.Мөнх-Эрдэнэ

3. А.Бүдээ

4. И.Батхүү

5. А.Хишигбаяр

Хараат бус гишүүн

1. С.Цолмон

2. Н.Хангай

3. Ц.Лхамсүрэн гэсэн тогтоолд хувьцаа эзэмшигчид 100 хувийн санал өгснийг тоолов.

ДАРГА:

Э.МАНДАХНАРАН

ГИШҮҮД:

Ч.ЭНХТӨР

Б.УРАНТӨГС

**“ШИВЭЭ-ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН  
КОМИССЫН ТОГТООЛ**

2025.04.24

Дугаар 08

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9, 63 дугаар зүйлийн 63.4, 63.5, 67 дугаар зүйлийн 67.3, 71 дүгээр зүйл, 72 дугаар зүйл, 77 дугаар зүйлийн 77.2, 77.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 880 дугаар тогтоолын хавсралт “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”, Шивээ овоо хувьцаат компанийн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 3.2.4, 3.2.5 дэх заалт, Шивээ Овоо хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 25/06 дугаар тогтоол, хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. “Шивээ-овоо” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдээр сонгох санал хураалт явуулж, олонхийн санал авсан дараах хүмүүсийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдээр батлахыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд уламжилсугай. Үүнд:

Ердийн гишүүн

1. Д.Нямдэлгэр 12078610 санал
2. Л.Наранчимэг 12078185 санал
3. Ц.Төгсбуян 12078167 санал
4. Д.Билгүүн 12078172 санал
5. А.Бүдээ 12078162 санал
6. И.Батхүү 12078162 санал

Хараат бус гишүүн

1. С.Цолмон 12078162 санал
2. П.Баянсан 12078162 санал
3. Ц.Лхамсүрэн 12078162 санал авсан байна.

ДАРГА:

Э.МАНДАХНАРАН

ГИШҮҮД:

Ч.ЭНХТӨР

Б.УРАНТӨГС

**“ШИВЭЭ-ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН  
КОМИССЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025.04.24

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9, 63 дугаар зүйлийн 63.4, 63.5, 67 дугаар зүйлийн 67.3, 69 дүгээр зүйлийн 69.1, Шивээ Овоо хувьцаат компанийн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 3.2.4, 3.2.5 дэх заалт, Шивээ-Овоо хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 25/06 дугаар тогтоолыг хэрэгжүүл ажиллалаа.

“Шивээ-Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр 10:00 цагаас Шивээ-Овоо ХК-ийн Улаанбаатар хот дахь хурлын танхимд хуралдлаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг “Эрдэнэс-Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт удирдан явууллаа. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 09.00-10.00 цагт явуулсан.

Шивээ-Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 13.419.101 ширхэг хувьцаа эзэмшдэг 1.561 хувьцаа эзэмшигчдээс брокерын пүүсүүдээр дамжуулан хуралд оролцох санал 0 ирсэн байна. Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч “Эрдэнэс Монгол” ХХК /90%/ 12.077.191 ширхэг хувьцааны эрхтэй, бусад хувьцаа эзэмшигчдийг төлөөлж 3 хүн итгэмжлэлээр, 29 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр ирж нийт 12078235 ширхэг хувьцаатай 33 хувьцаа эзэмшигчид хуралд оролцож хурлын ирц 90.0077 хувьтай байна.

Ирцийн бүртгэлд 90.0077 хувьтай оролцлоо.

Хурал 13.22 цагт дуусав.

Шивээ-Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 13,419,101 ширхэг саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс 12078235 ширхэг саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид оролцож хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлсэн асуудалд доорх байдлаар саналаа өгсөн байна.

Хурлаар хэлэлцэх асуудлыг хэлэлцэн тогтоол гаргасан байна.

1. “Шивээ-Овоо” ХК-ийн 2024 оны үйл ажиллагаанд Төлөөлөн удирдах зөвлөлөөс хийсэн дүгнэлтийг зөвшөөрч, компанийн 2024 оны үйл ажиллагааг “Сайжруулах шаардлагатай” гэж дүгнэх тухай тогтоолд дараах байдлаар санал өгсөн байна.

|            |                                    |
|------------|------------------------------------|
| Зөвшөөрсөн | 12078235 санал буюу 100 хувь       |
| татгалзсан | ..... санал буюу ..... хувь        |
| түдгэлзсэн | ..... санал буюу ..... хувь байна. |

**2024 ОНЫ АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

2. “Шивээ-Овоо” ХК-ийн 2024 оны санхүүгийн аудитлагдсан тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс хийсэн дүгнэлтийг зөвшөөрч, компанийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагааг “Хангалттай” гэж дүгнэх тухай тогтоолд дараах байдлаар санал өгсөн байна.

|            |                              |
|------------|------------------------------|
| Зөвшөөрсөн | 12078235 санал буюу 100 хувь |
|------------|------------------------------|

|            |       |            |             |
|------------|-------|------------|-------------|
| татгалзсан | ..... | санал буюу | хувь        |
| түдгэлзсэн | ..... | санал буюу | хувь байна. |

3. Тус компани нь 2024 оны санхүүгийн тайлангаар ногдол ашиг төлсний дараа төлбөрийн чадвартай байх нөхцөлийг хангахгүй байх тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй гэсэн тогтоолд дараах байдлаар санал өгсөн байна.

|            |             |            |               |
|------------|-------------|------------|---------------|
| Зөвшөөрсөн | 12078235    | санал буюу | 100 хувь      |
| татгалзсан | .....0..... | санал буюу | 0 хувь        |
| түдгэлзсэн | .....0..... | санал буюу | 0 хувь байна. |

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны тайланг "хангалттай" гэж үнэлж, тогтоолын төсөлд дараах байдлаар санал өгсөн байна.

|            |          |            |             |
|------------|----------|------------|-------------|
| Зөвшөөрсөн | 12078235 | санал буюу | 100 хувь    |
| татгалзсан | .....    | санал буюу | хувь        |
| түдгэлзсэн | .....    | санал буюу | хувь байна. |

5. "Шивээ Овоо" хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дараах гишүүдийн бүрэн эрхийг энэхүү тогтоол гарсан өдрөөс эхлэн дуусгавар болсонд тооцсугай. Үүнд

Ердийн гишүүн

1. Д.Нямдэлгэр

2. В.Мөнх-Эрдэнэ

3. А.Бүдээ

4. И.Батхүү

5. А.Хишигбаяр

Хараат бус гишүүн

1. С.Цолмон

2. Н.Хангай

3. Ц.Лхамсүрэн гэсэн тогтоолын төсөлд хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгсөн.

|            |             |            |               |
|------------|-------------|------------|---------------|
| Зөвшөөрсөн | 12078235    | санал буюу | 100 хувь      |
| татгалзсан | .....0..... | санал буюу | 0 хувь        |
| түдгэлзсэн | .....0..... | санал буюу | 0 хувь байна. |

6. "Шивээ-Овоо" ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох кумулятив аргаар нийт 108 703 944 саналын эрхээс 108 703 944 саналын эрхээр ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох санал хураалт явуулж 31 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна.

- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг сонгох батлах

Ердийн гишүүн

1. Д.Нямдэлгэр 12078610 санал

2. Л.Наранчимэг 12078185 санал

3. Ц.Төгсбуян 12078167 санал

4. Д.Билгүүн 12078172 санал

5. А.Бүдээ 12078162 санал

6. И.Батхүү 12078162 санал

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгох  
батлах

1. С.Цолмон 12078162 санал

2. П.Баянсан 12078162 санал

3. Ц.Лхамсүрэн 12078162 санал авч ТУЗ-ийн хараат бус гишүүнд  
сонгогдох болзлыг хангасан байна.

Тэмдэглэл хөтөлсөн:

Б.УРАНТӨГС

Хянасан: ДАРГА:

Э.МАНДАХНАРАН

ГИШҮҮН

Ч.ЭНХТӨР

Ч. Энхтөр